



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

.... оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.13.1, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацааг тогтоох журам”-ыг баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), програм хангамжийг даалгаврын дагуу боловсруулж 2024 оны ... дугаар сарын ...-ны өдрийн дотор аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Батсүх)-д даалгасугай.

ДАРГА

Л.МӨНХЗУЛ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН УЛМААС СУЛ ЗОГССОН
ХУГАЦААГ ТОГТООХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: ЖРМ-ХШГ -2023

Баталсан: НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Л.МӨНХЗУЛ

Хянасан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА Ц.ГАНЦЭЦЭГ

Боловсруулсан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.ЛХАГВАДОРЖ

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	Дардас
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



Журмын агуулга

1. Нийтлэг үндэслэл
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацааг тогтоох
6. Сул зогссон хугацааны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх Хариуцлага
7. Хариуцлага
8. Хэрэгжүүлэх хугацаа



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН УЛМААС СУЛ ЗОГССОН ХУГАЦААГ ТОГТООХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн дагуу үйлдвэрлэлийн ослын улмаас ажил олгогчид учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацааг тогтооход энэхүү журмыг баримтална.

1.2. Энэ журмаар үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон ажил олгогчийг тодорхойлох, мэдээлэл солилцох, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагаас дүгнэлт гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Үйлдвэрлэлийн байранд цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох ослын нөлөөг арилгах зориогоор сул зогссон хугацааг үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацаатай адилтгаж үзнэ.

1.4. Ажил олгогч, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан байгууллага нь ажлын байранд үүссэн үйлдвэрлэлийн осолд холбоотой мэдээллийг үнэн зөв гарган, тодорхойлох үүрэг хүлээнэ.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журмын хамрах хүрээ нь ажил олгогч, даатгуулагч, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан болон нийгмийн даатгалын байгууллага байна.

ГУРАВ. Хамаарах талууд

3.1. Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, ажил олгогч, даатгуулагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

4.1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацааг тогтоох

5.1. Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс ажлын байранд тоног төхөөрөмж, барилга байгууламж эвдрэх, нурах, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох ослын үед үүссэнээс учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор тухайн ажлын байранд тодорхой хугацаагаар үйл ажиллагаа тасалдахыг үйлдвэрлэлийн ослын улмаас сул зогссон хугацаа (цаашид “сул зогссон хугацаа” гэх) гэнэ.

5.2. Даатгуулагчийн ажлын байранд гарсан үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, мэдээлэх, тодорхойлоход “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх дүрэм”-ийг баримтлана.

5.3. Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хөдлогын улмаас үйл ажиллагаа нь түр зогссон нэгж (цех, тасаг зэрэг)-ийн талаар нотлох баримт мэдээллийг гарган, учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээхэд шаардагдах хугацааг тодорхойлж Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчийн баталгаажуулсан “Үйлдвэрлэлийн ослын акт”, Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн тогтоосон “Хурц хөдлогын дүгнэлт”-д тусгуулсан байна.

5.4. Сул зогссон хугацааг тооцоход “Үйлдвэрлэлийн ослын акт”, “Хурц хөдлогын дүгнэлт”-ийг үндэслэнэ.

ЗУРГАА. Сул зогссон хугацааны үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх

6.1. Үйлдвэрлэлийн осол, хурц хөдлогын нөлөөгөөр сул зогссон хугацаанд тухайн ажлын байранд (цех, тасаг зэрэг) ажилладаг ажилтны цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдох ажил олгогчийн төлбөл зохих үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлнө.

6.2. Ажлын байран дахь сул зогссон хугацааг сараар тооцно. Сул зогссон хугацаа нь нэг сар хүрэхгүй тохиолдолд уг сул зогссон хугацааг нэг сараар тооцож энэ журмын 6.1-д заасны дагуу шимтгэлийг чөлөөлнө.

ДОЛОО. Хариуцлага

8.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүргийн бусад байгууллага хяналт тавина.

8.2. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд Төрийн албаны болон Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

НАЙМ. Хэрэгжүүлэх хугацаа

9.1. Энэхүү журмыг 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллана.